

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг




Соронз бидний амьдрал ямар хэрэгтэй вэ? Бид мэддэггүй л болохоос бидний өдөр тутамд ашигладаг төрөл бүрийн эд зүйлс соронзын тусламжтай ажилладаг. Тиймээс бид соронзын шинж чанар, түүнтэй ажиллах аюулгүй ажиллагааны дүрэмд суралцах нь зүйтэй юм.

Даалгавар

- 1 Соронзтой хэрхэн харьцах талаар мэдээллийг уншаад, найз, нөхөд, дүү нартаа зориулж соронзтой зөв харьцах тухай зөвлөмж бичээрэй.

Гар утас, компьютер, телевиз, плитка зэрэг бүхий л цахилгаан хэрэгсэлд их бага хэмжээний соронз агуулагддаг. Тиймээс эдгээр хэрэгсэлд соронзыг ойртуулахад эвдрэх, гэмтэх аюултай гэнэ шүү. Мөн соронзыг яавч залгиж болохгүй. Бидний ходоод гэдсийг гэмтээх аюултай. Бас хэзээ ч соронзыг унагах юмуу хүчтэй цохиж болохгүй. Учир нь хүчтэй доргилтоос соронз өөрийн шинж чанараа алдана шүү, хүүхдүүд ээ!



ЗӨВЛӨМЖ:

.....

.....

.....

.....

- 2 Дараах зүйлсээс дотроо соронз агуулсныг дугуйлаарай.



- 3 Хоол, хүнсээ эрүүл, аюулгүй хадгалахад хамгийн сайн туслагч бол хөргөгч билээ. Тэгвэл хүүхдүүдээ хөргөгчний хаалгаа нээж хааж туршиж үзээд, энгийн шүүгээний хаалгатай харьцуулан дараах асуултад хариулаарай.



Энгийн шүүгээнээс ямар ялгаатай байна вэ?

.....

.....

.....

Яагаад хөргөгчний хаалгыг нээхэд илүү хүч шаардагдаж байна вэ?

.....

.....

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:





Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Соронзод юу татагддаг вэ? Соронзын гол шинж чанар нь тодорхой материалаар хийгдсэн эд зүйлсийг өөртөө татах шинж юм. Тэгвэл тэдгээр тодорхой материал нь юу юм бол? Дараах даалгаврыг гүйцэтгэх явцдаа олж мэдэцгээе.

Даалгавар

- 1 Хүснэгтэд өгөгдсөн материалаар хийсэн эд зүйлсийг гэрээсээ хайж олоорой. Тэдгээр эд зүйлс соронзод татагдах эсэхийг тодорхойлоод хүснэгтэд тэмдэглээрэй. Туршилтыг гэр бүлийн гишүүдийн тусламжтай, соронзтой аюулгүй ажиллах дүрмээ баримтлан гүйцэтгээрэй.

№	Сонгосон эд зүйл	Ямар материалаар хийсэн	Соронзод татагдаж байгаа эсэх
1		Хуванцар	
2		Хөнгөнцагаан	
3		Төмөр	
4		Шил	
5		Зэс	
6		Хөвөн даавуу	
7		Мод	

Туршилтын үр дүнг дүгнэж бичээрэй:

.....

.....

.....

- 2 Соронзыг хуурамч соронзноос хэрхэн ялгах вэ?

.....

.....

- 3 Чи санамсаргүйгээр нэг шуудай төмөр бичгийн хавчаар болон хөнгөн цагаан зоосыг хооронд нь хольчихжээ. Тэдгээрийг хэрхэн хялбар аргаар ялгаж болох вэ?

.....

.....

.....



Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг




Соронз нь төмөр, ган, никель зэрэг соронзон металлуудыг татдагийг бид мэднэ. Тэгвэл соронз хүрэх үедээ л татдаг уу? Соронзон үйлчлэл яаж явагддаг вэ? Бид юуг мэдэх хэрэгтэй вэ? гэдэг талаарх даалгаврууд ажиллая.

Даалгавар

1 Соронзны соронзон үйлчлэл аль хэсэгтээ хамгийн их, аль хэсэгтээ хамгийн бага байдаг вэ? А, Б, В хэсгүүдээс сонгоорой.

1. Соронзын (...), (...) хэсгүүд хамгийн хүчтэй.
2. Соронзын хамгийн хүчтэй хэсгийг гэдэг.
3. Соронзын (...) хэсэг хамгийн бага соронзон үйлчлэлтэй.



2 Зааврын дагуу туршилтыг гүйцэтгээд, туршилтын үр дүнг тайлбарлан бичээрэй.

Туршилтын заавар:

Хэрэглэгдэхүүн: Том, жижиг хавтгай соронз, төмөр бичгийн хавчаарууд, зузаан ном.

1. Нэг ширхэг бичгийн хавчаарт жижиг соронзыг бага багаар ойртуулна. Бичгийн хавчаарт татагдаж эхлэх зайг тэмдэглээрэй. Энэхүү туршилтыг том соронзоор давтаж хийнэ. Ямар ялгаа ажиглагдсан бэ?
2. Бичгийн хавчаар дээр номны хэсэг хуудсыг тавиад дээр нь соронз тавьж бичгийн хавчаар татагдаж байгааг шалгана. Хэр зузаан болоход татагдахаа больж байна вэ?
3. Бичгийн хавчаарыг уртынх нь дагуу соронзоор хэсэг хугацаанд үрээд, өөр нэгэн бичгийн хавчаарт үйлчлээрэй. Юу ажиглагдаж байна вэ?

1. Жижиг соронз:

Том соронз:

2.

3.

3 Соронзон үйлчлэл, соронзын шинж чанарыг ашиглан бид ямар шинэ зүйлийг хийж болох вэ?

.....

.....

.....

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:

